***Т.Лхагва-Эрдэнэ,*** *ДХИС-ийн Удирдлагын академийн*
*8052 дугаар дамжааны магистрант, хошууч*
***Г.Наранбаяр,*** *ДХИС-ийн Удирдлагын академийн Шүүхийн*
*шийдвэр гүйцэтгэлийн удирдлага стратеги профессорын*
*багийн ахлах багш , хошууч*

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

## /Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд/

***Хураангуй:*** *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нийгмийн өвөрмөц харьцааг зохицуулагч төрийн тусгай байгууллага болохын хувьд хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас иргэний хэргийн шүүхээс гаргасан болон баталгаажуулсан шийдвэрийг хуулиар тогтоосон нөхцөл журмын хүрээнд гүйцэтгэж буй олон тпалт, хоорондоо холбоо бүхий ажиллагаануудыг хамарсан ойлголт бөгөөд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, даван туулах арга замыг тодорхойлох юм.*

***Түлхүүр үг:*** Иргэн, төлбөр төлөгч, төлбар авагч, гуравдагч этгээд, мөнгөн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, тэтгэлэг.

**Оршил:** Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл, эрх зүйн нийтлэг жишигт тулгуурласан Үндсэн хуулийг манай улс 1992 онд баталж, Улсын Их Хурлын тогтоолоор 1998 онд эрх зүйн шинэтгэлийг хууль зүйн хувьд баталгаажуулсан нь түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон.

Үндсэн хуульд бэхжигдсэн хүний эрх, эрх чөлөөг бодит зүйл болгон хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон хууль тогтоомжид өөрчлөлт орж, шинээр багагүй эрх зүйн актууд батлагдсаны дотор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль чухал байрыг эзэлдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны гол бөгөөд эцсийн зорилго бол шүүх болон хуульд заасан бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах явдал байдаг. Иймээс хуулийг хэрэгжүүлэх процессын үйл ажиллагаан дахь шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүрэг, ач холбогдол өндөр юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс нь Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажсан боловч уг харилцааны гол зохицуулалт, нөхцөл, журмууд нь нарийвчлагдан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулагдсан. Энэхүү хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгаа гэхээсээ

илүүтэйгээр тухайн хуулийг хэрэгжүүлэхэд ямар асуудал тулгамдаж байгаа болон түүний зохицуулалтыг хэрхэн оновчтой болгоход илтгэлийн зорилго оршино.

**Үндсэн хэсэг:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд явуулж улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт 2020 оны 3 дугаар улирлын байдлаар /гүйцэтгэх хуудас/ 42%-тай явагдсан нь өнгөрсөн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3%- иар өссөн үзүүлэлттэй байна.

2020 оны 3 дугаар улирлын байдлаар 315.7 тэрбум төгрөгийн төлбөрийг төлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 117.5 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2020 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэд хэдэн онцлог зохицуулалт орсоны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай заалт юм. Хуулийн энэхүү зохицуулалтын үр дүнд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 50,0 сая төгрөгөөс дээш төгрөгийн төлбөрийн үнийн дүн бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй 2148 төлбөр төлөгчийн, мөн тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй 1573 тэтгэлэг төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэн ажилласан байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өөрчлөн найруулсан бөгөөд тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах[1]"-аар хуульчилж өгсөн нь хүүхдийн тэтгэлэг төлөлтийн хувь хэмжээг нэмэгдүүлж, тэтгэлэг авагч хүүхдийн эрхийг хангахад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон.




[1] *Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь заалт*

Иргэн, захиргаа, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд: 1. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд төлбөрийн урд оны үлдэгдэл 19808 гүйцэтгэх баримт бичиг дээр шүүхээс шинээр 18983 гүйцэтгэх баримт бичиг ирсэнийг нийт шийдвэр гүйцэтгэгчдийн тоонд харьцуулвал нэг шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 164 төлбөрийн гүйцэтгэх баримт бичигт, мөн хүүхдийн тэтгэлэгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тооцоо гарч байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ. Хэрэв хуульд заасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хуулиар эрх олгогдсон, эсхүл тухайн шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтнаар гүйцэтгүүлж болохоор хуульчилсан. Тэгвэл зарим төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрх олгогдсон хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, урамшууллаар хөдөлмөрийн хөлсийг тооцон олгодог байх зохицуулалт оруулвал нэг талаас шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал буурч, нөгөө талаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түргэн шуурхай биелэгдэх нөхцөл боломж бүрдэх ач холбогдолтой байна.

2. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд тулгамдаж буй асуудал: Улсын хэмжээнд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй 446 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 180 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, одоогоор 266 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна. Захиргааны хэргийн шүүхээс гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байгааг дээрх тоон судалгаанаас харж болох юм.

Захиргааны хэргийн шүүхээс дараах төрлийн шийдвэрүүд гарч, түүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Газрын асуудлаар эрх бүхий албан тушаалтан захирамж, тушаал гаргахгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй байгаа,
- Төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн тогтоосон шийдвэр гаргахгүй, сонгон шалгаруулалт зарлахгүй, ажилгүй байсан хугацааны олговор олгохгүй байгаа,
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохгүй, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхгүй, хугацааг сунгахгүй байгаа
- Бусад

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлд Захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны албадлагын хэлбэрийг хуульчлахдаа “хариуцагч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар арга хэмжээ аваагүй тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах талаар арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдлийг түүний дээд шатны албан тушаалтанд хүргүүлэх”-ийг зааж өгсөн.

Гэтэл хуулийн энэхүү зохицуулалт нь практик дээр хэрэглэхэд ихээхэн учир дутагдалтай байна. Учир нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа

албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулахыг түүний дээд шатны албан тушаалтанд даалгана гэсэн боловч тэрхүү сахилгын шийтгэл нь ямар хэлбэртэй байх нь тодорхой бус, мөн цаашлаад хуулийн дээрх зохицуулалтаар шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүргүүлсэн мэдэгдлийн дагуу доод шатныхаа албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол өнөөдрийн байдлаар байхгүй байна. Мөн захиргааны хэргийн шүүх нь шүүхийн шийдвэртээ гүйцэтгэх арга, журам хугацааг тодорхой заадаггүй, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ сул, ажилгүй байсан хугацааны олговрыг гаргуулах гэхэд төсвийн байгууллагын төсөвт тухайн зардал суугаагүй гэх мэт хүчин зүйлээс шалтгаалж энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн хувь хэмжээ доогуур байна.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэдий хугацаанд ямар арга журмаар хэрхэн биелүүлэхийг тодорхой болгох, цаашлаад шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, албадлагын арга хэмжээг тодорхой болгох тухайлбал шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа албан тушаалтны хуульд заасан эрх хэмжээг тухайн шийдвэр биелэгдэх хүртэл хугацаанд түдгэлзүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлдэг байх зохицуулалтыг хуульд нэмэлтээр оруулж өгснөөр энэ төрлийн шүүхийн шийдвэр нэг мөр биелэгдэх боломжтой гэж үзэж байна.

3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө бүхий албадлагын арга хэмжээний төрөл, уг арга хэмжээг гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд банкны нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад тохиолддог учир дутагдалтай асуудалд үнэлэлт дүтнэлт гаргахыг хичээсэн.

Шийдвэр гүйцэтгэгчээс тогтоосон хугацаанд төлбөрийн үүргээ биелүүлээгүй төлбөр төлөгчийн хөрөнгийг худалдан борлуулах, эсхүл гүйцэтгэх баримт бичигт заасан тохиолдолд төлбөр авагчид шилжүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авна[1] гэж хуульчилсан. Гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа




гэсэн дараалалтай явуулдаг. Төлбөр төлөгчид мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд түүний хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хураан авч үнэлгээ тогтоолгон албадан болон үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар худалдан

[1] *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 54 дүгээр зүйлиин 54.1 дэх хэсэг*

борлуулж гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг.

Ихэнх тохиолдолд арилжааны банкууд анх барьцаат зээлийн гэрээгээр зээл олгосон байдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухайн барьцаа хөрөнгийг хураах ажиллагаа явуулж төлбөр авагч буюу банкнаас хөрөнгийн үнэлгээ авахад зээл олгохдоо үнэлсэн үнэлгээний 50 буюу түүнээс доош хувиар үнэлж төлбөр төлөгчдийн хөрөнгийг ихээхэн үнэгүйдүүлдэг сул тал ажиглагддаг.

Цаашлаад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд үнэлгээн дээр тохиролцоогүй тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр хөрөнгөд үнэлгээ хийлгэж, дуудлага худалдаагаар худалдан борлуулсан ч төлбөрийг бүрэн барагдуулж хүрдэггүй бөгөөд дахиад төлбөр үлдэх тохиолдол практикт элбэг байна.

2020 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд банкны нэхэмжлэлтэй 3909 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 874 материалыг дуусгавар болгосон бөгөөд одоо 3035 гүйцэтгэх гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хангалттүй байгаа нь төлбөр авагч банк төлөгчийн хөрөнгийг хэтэрхий их үнэгүйдүүлдэг нөхцөл байдлаас улбаатай гэж үзэж байна.

Энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн анх зээл авахдаа барьцаалсан барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулаад тухайн төлбөр төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болсонд тооцох зохицуулалтыг хуульд оруулснаар энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт нэмэгдэх боломж байна.

4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатанд төлбөр төлөгчийн хөрөнгөд хамгаалалт тогтоох буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авах нь өндөр ач холбогдолтой байгаа юм. Баталгаажуулах арга хэмжээ нь дараах төрлүүдтэй бөгөөд үүнд:

- ♦ хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх;
- ♦ хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох;
- ♦ хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох;
- ♦ нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах;
- ♦ тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах гэсэн төрлүүдтэй байдаг бөгөөд энэ нь зөвхөн нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатанд хийгддэг онцлог зохицуулалт юм.

Хуулийн дээрх зохицуулалтыг иргэд тэр бүр анхаардаггүйгээс шүүхэд нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгч бүр дээрх боломжийг ашиглаж чаддаггүй.

Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дээрх зохицуулалтыг нэхэмжлэгчийн хүсэл зоригоос үл хамаарч шүүхийн санаачилгаар баталгаажуулах арга хэмжээ хийгддэг болвол шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийг хамгаалж, тэдгээрийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөө нуун дарагдуулах, дансанд байгаа мөнгөн хөрөнгөө бусдад шилжүүлэх зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж, шүүхээс гарсан шийдвэр нэг мөр хурдан шуурхай биелэгдэх нөхцөл бүрдэх боломжтой юм.

5. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, анхаарах асуудал: Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ[1]. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг хуулиар зөвшөөрсөн ажлыг тогтоосон хугацаанд цалин хөлсгүйгээр хийлгэж, түүнийг хорих ангид байлгах бус нийгэмд учруулсан хор уршигаа нийтэд тустай ажил хийж арилган, засарч хүмүүжих боломж олгодог ял гэж ойлгож болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нийтэд тустай ажил хийлгэж байгаа байгууллагын үүрэг, хүлээлгэх хариуцлагыг зохицуулж өгсөн бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулах, ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангах, ялтны ажлын цагийг бүртгэж, ажлын гүйцэтгэл, ялтны гаргасан зөрчлийн талаар шийдвэр гүйцэтгэгчид тухай бүр мэдээлэх, ялтны ажлын цагийн бүртгэл, тодорхойлолтыг үнэн зөв гаргах, гэрээнд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон ажлын байранд ялтныг ажиллуулах үүрэгтэй ба нийтэд тустай ажил хийлгэж байгаа байгууллагын ажилтан энэ хуульд заасан ялтны гаргасан зөрчлийн талаар шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдээгүй, нуун дарагдуулсан, ялтны цагийн бүртгэлийг хуурамчаар бүртгэсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийтэд тустай ажил хийлгэх ялтай этгээдийг ажлын байраар хангах асуудлыг аймаг, нийслэл, орон нутгийн төр захиргааны байгууллагаас олгохоор заасан байдаг боловч эдгээр байгууллага нь ажлын байраар хангах идэвхи сул, шийдвэр гүйцэтгэгчээс түүнд өдөр тутам биечлэн болон цаг ашиглалтанд хяналт бүрэн тавих боломж нөхцөл бүрдээгүй, өнөөдрийн нөхцөлд хаана, ямар төрлийн ажил хийлгэх нь тодорхой бус, хэрэгжүүлэх нөхцөл боломж тааруу, дийлэнхдээ хот тохижуулах, гудамж талбайн хог цэвэрлэх, мод услах, байгууллагын цонх хаалга угаах зэрэг аар саархан ажил хийлгэхээс хэтэрдэггүй байгаагаас энэ төрлийн ял төдийлөн нэг мөр хэрэгжихгүй байна.

Иймд шүүхийн шийдвэрт тухайн нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх байгууллагыг тодорхой заан өгч тухайн ялтны ур чадвар, чадамж зэргийг нийгэмд үр өгөөжтэйгээр ашиглахад энэхүү ялын хэрэгжилт илүү үр нөлөөтэй байх юм.

[1] *Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйл*

## Санал

Дээрх хөндсөн асуудлуудын хүрээнд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж, хууль ёсны шаардлагыг ханган эцсийн дүндээ иргэдийнхээ эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхэд уг ажиллагааг гүйцэтгэгч субъектүүдийн ажиллах, үүргээ биелүүлэх эрх зүйн баталгаат орчинг бий болгох,
2. Орон нутгийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий алба хаагч болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн орон тоог нэмэх,
3. Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх зүйн мэдлэг, ажлын хариуцлага, идэвхи санаачлага зэргийг сайжруулах,
4. Зарим төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрх олгогдсон хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, урамшууллаар хөдөлмөрийн хөлсийг тооцон олгодог байх,
5. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэдий хугацаанд ямар арга журмаар хэрхэн биелүүлэхийг тодорхой болгох, цаашлаад шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, албадлагын арга хэмжээг тодорхой болгох,
6. Банкны нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичигт барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулаад тухайн төлбөр төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгох,
7. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийг хамгаалах буюу захиран зарцуулах эрхийг шүүх өөрийн санаачилгаар түдгэлзүүлдэг байх,
8. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх байгууллагыг шүүхийн шийдвэрт тусгаж өгдөг байх зэрэг саналыг дэвшүүлж байна.